

# Манмин Мэдээ

№ 43 2014 оны 2 сарын 2



## И Жей руг тэргүүн пасторын 2014 оны МЭНДЧИЛГЭЭ

“Бос, гэрэлт. Учир нь чиний гэрэл ирж, ЭЗЭНий цог жавхлан чиний дээр мандаж байна. Үзэгтүн, газрыг харанхуй бүрхэн, гүн харанхуй хүмүүсийг хучсан. Гэвч ЭЗЭН чиний дээр мандан, Түүний цог жавхлан нь чиний дээр үзэгдэнэ. Үндэстнүүд чиний гэрэл уруу, хаад нь чиний мандах туяа уруу ирнэ (Исаиа 60:1-3).”

Бүх хүн төрөлхтөнийг аврахыг хүсэж буй Бурхан энэ эцсийн үед авралын төлөвлөгөөгөө биелүүлэхийн тулд Манмин төв сүмийг Тэрээр босгон байгуулсан билээ. 1982 онд байгуулагдсанаас хойш өдийг хүртэл 31 жилийн турш манай сүм итгэлээрээ тууштай, зогсолтгүй дуулгавартай байж, Ариун Сүнсний хүч чадлаар дэлхийн хязгаар хүртэл Есүс Христийн сайн мэдээг тараах ерөөлийг авсан билээ.

Энэ нь өнгөрсөн гурван жилд бидний хоньчин болох тэргүүн пасторын үйлчлэл ба золиос, зүтгэлээр олон итгэгчид ухаарч, ариун байдлын ивээлийг авсанаар сүнслэг итгэл рүү, төгс сүнслэг итгэлтэй болж итгэлээр өсөн, шударга ёсны дагуу цаашид ч илүү олон хүн аврагдаж ийнхүү итгэлээр өсөх нөхцөл нь бүрдэж байгаа юм. Ингэснээр манай сүмд Бурханы агуу хүслийг биелүүлэх төгс сүнсний урсгал дотор итгэл болон хайраараа нэгдэж чадсан баг бүлгүүд бий болсон билээ. Гүн гүнзгий утга учиртай 2013 оны Христмас баяраас эхлэн сүнслэг бат бөх суурьтай энэ сүмийн нэр, хайрын баталгаа, Бурханы эрх мэдэлт хүчийг

дэлхийн бүх үндэстэнд болоод бүх хүмүүст илүү ихээр тараан таниулж, мэдүүлж байгаа Бурхандаа бүх алдар магтаал талархалыг өргөж байна.

Тэгвэл зочлон ирж байгаа 2014 оны шинэ жилээр Бурхан бидэнд ямар ивээл, ерөөлүүдийг бэлдсэн бол?

**Нэгдүгээрт, Бурханы өгсөн амлалт нь тэргүүн пасторын эрх мэдэлт хүчээр агуу гайхамшигтайгаар хэрэгжих болно.**

Энэ мэт Библид бичигдсэн Бурханы амлалтанд бүрэн төгс итгэж ирсэн тул Манмин Төв Сүм маань үй олон тэмдэгт гайхамшигуудаар, агуу эрх мэдэлт хүчийг баталсан олон гайхалтай үйлсээр дамжуулан хүмүүсийн зүрх сэтгэлийг өөрчилж, хайр, амь амьдралаа бүрэн зориулсан олон хүнийг Их Эзэн рүү хөтлөн замчилсан билээ. Ирж байгаа 2014 онд хоньчны хүчин дотор энэ сүмд Бурханаас өгсөн хүсэл зорилгыг, Солонгосын Христийн Сүмүүдийг шинэчлэх зорилгыг, дэлхийн бүх үндэстэн рүү хандсан эцсийн үеийн авралын зорилгынхоо дагуу бүхнийг гайхалтайгаар хийж гүйцэтгэх болно.

Хоёрдугаарт, Тэргүүн пасторын залбирлаар эрх мэдэлт хүчийг агуулсан гар алчуурын үйлчлэл дэлхийд эрч хүчтэй хийгдэх болно.

Өнөө үед ч тэргүүн пасторын залбирч өгсөн эрх мэдэлт хүчит гар алчуураар Ариун Сүнсний хүч чадал үйлчилж үүгээр дамжуулан хүмүүс амьд орших Бурхантай уулзаж, амьдралынхаа янз бүрийн хүнд хэцүү асуудлаа шийдүүлж, үл эдгэх өвчин, тахир дутуу хүн хүртэл эдгэрч Бурханыг алдаршуулж байна. Гадаадад гар алчуурын цуглаанаар Буддын, Хиндү, Лал, Иудейн шашинтай хүмүүс Их Эзэнийг хүлээн авч, Христэд итгэгч болж байна. 2014 онд тэргүүн пасторын мэдэлт хүч өсөхийн хирээр гар алчуурын хүч ч бас өсөх болно. Дэлхийн өнцөг булан бүрт 10,000 салбар сүм болон хамтран ажилах сүмүүдийн пастор ажилчид Бурханы хүслийг газар сайгүй биелүүлэх болно.

**Гуравдугаарт, Тэр “Гэрэлтэх Өргөө”-г босгон байгуулахаар удирдах болно.**

Ирэх 2014 онд Бурхан Өөрөө гэрэлтэх өргөөг үзэсгэлэнтэйгээр барихаар биднийг удирдаж Түүний алдар гайхамшигтайгаар илчлэгдэн эцсийн

үед олон хүний сүнсийг аврахын тулд алдрынхаа төлөө бүхнийг бэлтгэх болно. Гэрэлтэх өргөө хурдан баригдах, сүнслэг сэтгэлийг олж авахын төлөө сэтгэл гарган, хичээнгүйлэн шамдан залбирахыг та бүхнээс чин сэтгэлээсээ хүсч байна.

**Дөрөвдүгээрт, Дахин бүтээлийн хүч жинхэнэ утгаараа нөлөөлж эхлэх болно.**

Эхлэл 1:3т “Тэгээд Бурхан: Гэрэл бий болог! гэсэнд гэрэл бий болов” гэсэн байдаг. Бурхан Угийн дуугаа цацахад бүтээл бий болсон. Тэгвэл дахин бүтээх хүч гэж юу юм бэ? Бурханы бүтээсэн тэнгэр газар бүх бүтээлийг дахин шинэчлэх хүчийг хэлнэ.

Хайрт итгэгч ахан дүүс нар минь, Бурханы өгсөн хоньчны эрх мэдэлт хүчээр дахин бүтээх хүч чадал жинхэнэ хүч чадал жинхэнэ утгаараа гарч ирнэ бодоход л сэтгэл зүрхэнд тань баяр хөөр дүүрч байгаа биз дээ? 2014 онд угийн дуу бүрэн гарч төгс үр жимсээр илрэх болно. Хүний сэтгэлийн гүнд хүртэл нөлөөлж, өөрчлөх дахин бүтээлийн хүчээр Бурханы жинхэнэ хүүхэд болж тэргүүн пастортайгаа хамтдаа дэлхийг зорин давшигцаа! Халеллуяа!

# Хайр бүгдийг далдалдаг, бүгдэд итгэдэг, бүгдэд найддаг

“Хайр бол тэвчээртэй ... бүгдийг далдалдаг, бүгдэд итгэдэг, бүгдэд найддаг, бүгдийг тэсвэрлэдэг” (1 Коринт 13:4-7).



И Жей руг Тэргүүн пастор

Энэ дэлхийд “Хайр” гэдэг үгэнд дургүй хүн гэж нэг ч хүн байдаггүй. Амьдрах нөхцөл нь ямар ч хэцүү зовлон бэрхшээлтэй байлаа ч түүний дотор хайр бялхам дүүрэн байвал тэр хүн аз жаргалтай байж чадна. Харин сүнслэг хайр байхгүй хүн хичээн баян тансаг, баталгаатай амьдралтай байлаа ч жинхэнэ аз жаргалтай амьдрал гэгч юу байдгыг олж ч чадахгүй, мэдэх ч үгүй амьдрах болно. Хүмүүсийн хувьд хайр гэдэг нь үүрд мөнх хэзээ ч хувирашгүй сүнслэг хайр байх хэрэгтэй юм.

1 Коринт 13 бүлэгт сүнслэг хайрын талаар “Хайр бол бүгдийг далдалдаг, бүгдэд итгэдэг, бүгдэд найддаг” гэсэн байдаг. Үүнийг сүнслэг утгаар нь судлан, хэрхэн яаж энэхүү сүнслэг хайрыг олж авч болох талаар үзэцгээе.

### 1. Хайр бүгдийг далдалдаг

Есүс Христийг бид хүлээн зөвшөөрсөний дараа Бурханы Үгийн дагуу амьдрахыг хичээн зүтгэж явахад маш олон зүйлийг тэсэж тэвчих хэрэгтэй болдог. Хэрэв та уурлаж, бусдаас болж тавгүйтэж, дургүйцэх тэр л үед тэсэж, мөн өөрийн хүсэл сонирхол, эрх ашгийн төлөө хийх хүслээ ч тэвчих хэрэгтэй болдог.

Тиймээс сүнслэг хайрын 15 шинж чанарын хамгийн эхнийх нь ‘Хайр бол тэвчээртэй’ гэсэн байдаг. Өөрийн зүрх сэтгэлдээ байгаа худал хуурмаг, ёс бус зүйлсээ хаяхын тулд ямар ч зовлон зүдгүүр хэцүү байдалд тэвчээртэй байж, өөрсдийнхөө эсрэг тэмцэхийг хэлдэг.

Тэгвэл ‘хайр бол бүгдийг далдалдаг’ гэдэг нь ямар утгатай вэ? Энэ өөрийн зүрх сэтгэлээ үнэнээр өөрчилсөний дараа бусдаас ирэх бүх зовлон дарамтыг тэвчих болдог. Харин энэ нь ‘Хайр бол тэвчээртэй’ гэдгээс илүү их өргөн гүн утгаар хэрэглэж байгаа бөгөөд энэ нь

“Сүнслэг хайрын эсрэг бүх зүйлийг тэвчинэ” гэсэн утгатай юм.

Өөрөөр хэлбэл махан биеийн гэм нүгэл, худал хуурмаг гэх мэт хорон муугийн бүх хэлбэрийг тэвчинэ гэсэн үг юм. Жишээ нь, тэвчээргүй байх, хорон муу сэтгэл зүрхтэй байх, уурлах, дээрэлхэх, бүдүүлэг зан, өөрийн эрх ашгийг хайх, зохисгүй авирлах, муутай тооцоо хийх, зөвт бус байдалд баярлах гээд бүгд сүнслэг хайрын эсрэг зүйл юм.

Энд тэвчих гэдэг нь зөвхөн биеэ барих, албаар тэснэ, тэвчинэ гэсэн үг биш харин бидний зүрх сэтгэлээс гарч байгаа хайрын эсрэг зан чанаруудыг, худал хуурмагуудыг ор үндэсгүй болтол нь үгүй хийж, хаяхыг хэлж байгаа юм. Энэ нь яг л бид зүрх сэтгэлээ цэвэрлэх хийх мэт юм. Ингэж махан биеийн бүх зүйлсийг тэр чигээр нь орхивол, зөвхөн сүнслэг хайраар дүүрэн сүнслэг хүмүүс болж чадна.

Яг үнэндээ бид зүрх сэтгэлдээ нэгэнт сүнслэг хайрыг бий болгочихвол тэснэ, тэвчинэ гэдэг үг хэрэггүй болох юм. Яагаад гэвэл Бурханыг дээд зэргээр хайрладаг учраас хайрын эсрэг ямар нэгэн зүйлс бодогддоггүй, хийж үйлдэж ч чадахгүй болдог юм. Мөн бидний зүрх сэтгэлд хорон муугийн ямар ч хэлбэр байхгүй тул бусдын алдаа дутагдал, буруу зүйлсийг олж хардаггүй байна.

Гэмт хүмүүсийг аврахаар энэ дэлхийд ирсэн Есүстэй хүмүүс яаж харьцсан бэ? Есүс бүх зүйлийг зөвхөн сайхан сэтгэлээр хийсэн ч хүмүүс Түүнийг доромжилж, үгүйсгэж эцэст нь загалмайд цовдолсон билээ. Есүс өөрөө Бурхан байсан ч хүмүүсийн адил та бидэн шиг л махан биеийг өмсөн төрсөн юм. Тэр Өөрийг нь доромжилж байгаа хүмүүсийн төлөө “Аав аа, тэднийг уучлаач. Учир нь тэд юу хийж байгаагаа мэдэхгүй байна” (Лук 23:34) гэж залбирч байсан.

Есүс бүхнийг далдалж, Түүний агуу хайрын үр дүнд бид аврагдсан тул Түүнийг хүлээн зөвшөөрөөгүй хэн ч Бурханы хүүхэд болж чадахгүй. Бид үхлээс мөнхийн амь руу орсон юм. Бурхан бидэнд хайртай учраас Тэр биднийг одоо хүртэл тэвчсээр мөн Түүний жинхэнэ хүүхэд болон өөрчлөгдөхийг хүлээсээр л байгаа.

### 2. Хайр бүгдэд итгэдэг

Хэрэв та хэн нэгнийг чин сэтгэлээсээ хайрлавал та түүний бүх зүйлд итгэх болно. Бүр хичнээн их алдаа дутагдалтай байсан ч та түүнд итгэхийг хичээх болно. Та түүнийг өөрчлөгдөнө гэдэгт итгэж байгаа учраас түүнийг хайрын нүдээр харж чаддаг байна. Ингэж итгэж байгаа

нь та түүнд хайртай гэдгээ баталж байгаа хэрэг юм.

Итгэлийг хайрыг хэмжих хэмжээ гэж хэлж болно. Тиймээс Бурханд төгс итгэнэ гэдэг нь Түүнийг төгс хайрлана гэсэн үг юм. Абрахам Бурханд төгс итгэсэнээрээ “итгэлийн эцэг” Бурханы анд нөхөр гэж дуудагдах болсон. Үхсэнийг хүртэл дахин амилуулах хүчтэй Бурханд төгс итгэсэн учраас тэр өөрийн цорын ганц хүү Исаагыг хүртэл өргө гэхэд ямар ч эргэлзээгүйгээр дуулгавартайгаар дагасан тийм чин сэтгэлийн итгэл байсан юм.

Үүнээс бид хайр бүгдэд итгэдэг гэдгийг харж болно. Бурханыг төгс хайрладаг хүмүүс Бурханы үгэнд 100% итгэдэг. Мөн түүнчлэн бүгдэд итгэдэг учраас бүгдийг тэсвэрлэдэг юм. Сүнслэг хайрын эсрэг бүхнийг тэсвэрлэхийн тулд бидэнд итгэл байх хэрэгтэй гэсэн үг. Өөрөөр хэлбэл, бид зөвхөн Бурханы үг бүрт итгэх тэр л үед зүрх сэтгэлээ шинэчилж, сүнслэг хайрын эсрэг бүх муу муухай зүйлсээ хаяж, бүх зүйлд итгэж найддаг чадна.

Бурхан биднийг яаж хайрласан бэ? Тэр Өөрийн цорын ганц хайртай хүүгээ гэмт бидний төлөө харамгүйгээр өгч авралын үүд хаалгыг нээсэн билээ. Энэ нь бид эхлээд Бурханыг хайрлаж, итгэсэн гэсэн үг биш. 1 Иохан 4:9-10д бичсэнчлэн Бурхан Өөрөө эхлээд биднийг хайрлаж, итгэсэн учраас бид Бурханы хайр руу ирсэн. Ингэж Түүнд итгэж бид илүү их сүнслэг хайрыг олж авах тусам өөрт байгаа хайрынхаа хэмжээнээс шалтгаалаад төгс итгэлийг ч мөн олж авдаг юм.

Зүрх сэтгэлдээ байгаа хорон мууг хаясанаараа бид сүнслэг хайрыг олж авах бүрэн боломжтой. Сүнслэг хайрыг олж авсан хүмүүс бүх хүнд итгэдэг. Хэдий олон алдаа дутагдал сул талтай ихтэй, найдваргүй тэднийг итгэлээрээ сүнслэг хайраар харж чаддаг. Мөн тэд өөрсдийгөө ч итгэлээрээ хардаг юм. Хэдий их алдаа дутагдал, сул тал байлаа ч гутарч, сэтгэлээр унадаггүй харин ч хэзээ ч бууж өгдөггүй агуу хүчирхэг Бурхан тэднийг өөрчлөх болно гэдэгт итгэдэг. Ариун Сүнс бидний зүрх сэтгэлд үргэлж “Чи хийж чадна, Чи чадна” гэж хэлдэг бөгөөд бид итгэлийнхээ хирээр хийж гүйцэтгэх болно.

### 3. Хайр бүгдэд найддаг

Хүмүүс заримдаа бусдын үйлдэл таалагдахгүй байгаа учраас өөрийнхөө хүслийн дагуу өөрчлөхийг хүсдэг. Өчүүхэн жаахан зүйлийг ч өвөрлөөд өнгөрөөж чадахгүй хэрэлдэж, маргалдвал бусдыг өөрчлөх гэдэг нь утгагүй

юм. Тиймээс бусдыг өөрчлөгдөхийг хүлээхээс илүү өөрсдийгөө өөрчлөхийг хичээх хэрэгтэй. Харин та өрөөл бусдыг хайраар харж, хүлээж өгөх шаардлагатай байдаг.

Бүгдэд найддаг гэдэг нь таны итгэдэг зүйл тань бодитоор биелэх хүртэл хүсэн хүлээхийг хэлж байгаа юм. Өөрөөр хэлбэл, хэрэв та Бурханд хайртай бол Түүний үгэнд итгэж, бүх зүйл Бурханы үгийн дагуу хийгдэх болно гэдэгт найдаж чадна. Та Бурханы хаанчлалд үзэсгэлэнтэй тэнгэрийн оронд үүрд мөнх Бурхан Аавтай хамт хайраа хуваалцах тэр л өдөрт найддаг байгаа. Тийм учраас та бүхнийг тэвчиж, итгэлээрээ уралдаанд гүйж байгаа билээ.

Харин энэ дэлхийн хүмүүс бүх зүйлд тэнгэрийн орны итгэл, найдвар юу ч байхгүй зүгээр л дэлхийн амьдарлаар амьдарч байна. Тэдний амьдрал ямар ч найдваргүй учраас дэлхийн амьдралын төгсгөл нь тэдний амьдралын төгсгөл юм. Тэд нар зөвхөн урсгалаар, махан биеийн зугаа цэнгэлийг хөөж амьдардаг учраас жинхэнэ сэтгэл хангалуун байдал, аз жаргал гэгчийг мэддэггүй, өдөр бүрийн амьдралаа жинхэнэ үнэн бодит итгэл найдваргүйгээр хэцүүхэн өнгөрөөдөг. Тэгээд үхэх өдрөө хүртэл магадгүй ирээдүйнхээ төлөө санаа зоволт, айдастайгаар өдөр өдрийг өнгөрөөдөг.

Гэвч Бурханд итгэгч хүмүүс үүний яг эсрэг бүх зүйлд найддаг, Матай 7:13-14д хэлсэн шиг нарийн замаар явж чадна. 1 Коринт 15:19д элч Паул “Хэрэв бид зөвхөн энэ амьдралдаа Христ дотор найдсан бол бид бүх хүмүүсээс хамгийн өрөвдөлтэй нь болно.” гэж хэлсэн.

Махан биеийн үзэл бодлоор бол Христчин итгэлийн амьдралаар амьдрах нь үргэлж биеэ барьж, өөрийгөө хянаж хэцүү ядаргаатай амьдраад байгаа юм шиг санагддаг. Үл итгэгч хүмүүст бидний амьдрал үнэхээр хэцүү, нарийн зам мэт санагддаг. Гэвч итгэгч бидний хувьд үзэсгэлэнт Тэнгэрийн Оронд үүрд мөнх амьдрах зам учраас бусад ямар ч амьдралаас илүү аз жаргалтай амьдрал юм. Эндээс хайр бол хувирашгүйгээр хүлээдэг, итгэсэн бүх зүйл биелэх хүртэл бүгдэд найддаг гэдгийг сурч болно.

Хайрт ахан дүүс нар минь, Бурхан та бүхнийг сүнслэг хайрыг олж авч эзэмшээд Түүний жинхэнэ хүүхэд болохыг хүлээсээр л байгаа. Түүний хувьд мянган өдөр нэг л өдөр шиг байдаг. Тиймээс бид бүх хүмүүсийг итгэлээрээ харж, бүхнийг тэвчсэнээр олон хүнийг авралыг зам руу замчилсан та бүхэн болохийг Их Эзэнийхээ нэрээр хүсэн ерөөе!


## Монгол Манмин Сүм

### Мөргөлийн цаг

Мөргөл	Цаг
Их мөргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойш мөргөл	Ням гариг 13: 40
3-дахь өдрийн мөргөл	3 дахь өдөр 18: 00
5-дахь өдрийн мөргөл	5 дахь өдөр 22: 00
Хүүхдийн мөргөл	ням гариг 10: 30
Сурагч залуучуудын мөргөл	Хагас сайн өдөр 16: 30


### Залбирлын цаг

Ангилал	Цаг	Удирдагч
Даниел үүрийн залбирал	Даваа- баасан 05: 00- 06: 00	Ш. Золзаяа (Том хүний баг хариуцагч)
Даниел өдрийн залбирал	Даваа- баасан 09: 00- 10: 00	П. Уртнасан (2Том хүний баг хариуцагч)
Даниел оройн залбирал	Өдөр бүр 18: 30- 20: 00	П. Батзориг (Чуулганы хариуцагч)



**Хаяг:** Баянзүрх дүүрэг, 13-р хороолол 6-р хороо, ой булан- 6 иргэний А.О.С  
**Утас:** чуулганы- 5525-7637 чуулганы хариуцагч- П. Батзориг 9117-0773

www.manmin.org  
www.manmintv.org



1 Коринт 13:4-7д сүнслэг хайрын 15 шинжийг тодорхойлон зааж өгсөн байдаг билээ. Тэдний нэг нь хайр муутай тооцоо хийдэггүй гэж байгаа. Энд 'муу' гэдгийг ёс бус, хорон мууг төлөөлүүлэн хэлсэн. Тиймээс Бурханы хүүхдийн хувьд хэр зэрэг сүнслэг хайр танд байна вэ? Одоо гурван төрлийн хорон муу бодлын хэлбэрийг хараад, өөрийгөө хянан шалгаж, хорон муугийн бүх хэлбэрүүдийг хурдан хаяж, үзэсгэлэнтэй сайхан сүнслэг хайрыг эзэмшиж, өөрийн болгоод аваарай!

Та бусдыг бүтэлгүйтэхийг хүсдэг үү?

01

Өөрөөс тань илүү сайн суралцаж байгаа, эсвэл ажил бизнес нь танаас хавьгүй сайн яваа хэн нэгнийг харахдаа амжилтанд хүрэхгүй дээ, нэг их хол явахгүй дээ, харж л байя, нэг бүтэлгүй юм болчихоосой гэх мэтээр бодвол энэ нь хорон муу бодол юм. Тэгээд хэн нэг нь таны нүдэн дээр гэнэт бүтэлгүйтвэл 'Болж! Ийм юм болно гэж би бүр мэдээд байсан юм!' гэж бодох тохиолдол байдаг.

Гэвч хэрэв таны дотор жинхэнэ хайр байвал танд хэзээ ийм хорон муу бодол бодогдохгүй. Та хайртай хүнээ үргэлж эрүүл саруул, элдэв аюул ослоос хол байгаасай гэж хүсдэг. Таны зүрх сэтгэлд сүнслэг хайр байхгүй учраас та бусдыг буруу, муугаар бодож, бусдын зовлонд заримдаа баярладаг. Тэгээд та түүнийг нь цаашаа хэн нэгэнд ярьж тараадаг байна.

Та нэг уулзалтанд очлоо гэж бодъё. Тэнд нэг хүн хэн

нэгний тухай таагүй хов жив ярьж байхыг сонсоод тэр ярианд оролцох хүсэл төрж байвал та өөрийнхөө зүрх сэтгэлийг одоо нэг шалгаад үзэх хэрэгтэй. Танд бусдыг муулах, хов жив ярих дур хүсэл байна гэдгийг илчилж байгаа хэрэг юм. "Нүгэл хилэнцийг далдлагч хайрыг эрдэг. Харин хэргийг дахин дахин ярьдаг хүн дотнын анд нөхдийг салгадаг" (Сургаалт үгс 17:9).

Сайхан сэтгэлтэй, зүрх сэтгэл дотор нь хайр байгаа хүмүүс бусдын сул тал, алдаа дутагдлыг нуухыг хичээдэг. Мөн бидэнд сүнслэг хайр байвал бусдын эд хөрөнгө, сайн сайханд атаархдаггүй харин ч илүү сайн сайхан элбэг дэлбэг, бусдын хайрыг татаж яваасай хэмээн хүсдэг. Ром 12:14д "Та нарыг хавчигч хүмүүсийг ерөө. Ерөө, харин бүү хараа" гэж бичсэн байдаг тул бидэнд муу зүйл хийсэн хүмүүсийг бид чин сэтгэлээсээ ерөөдөг.

Та бусдыг буруутгаж, шүүн дүгнэдэггүй юу?

02

Хэрэв танд сүнслэг хайр байвал та юуны түрүүнд элдвийн муу бодлыг боддоггүй байна. Та хэн нэгний тухай тааламжгүй мэдээлэл сонслоо ч өөрөө шалгаж үзэхээс нааш түүнийг буруутгаж, яаравчлан шүүн дүгнэхгүй. Та хэн нэгэнд үнэхээр их хайртай бол түүнийг аль болох зөв, сайн талаас нь бодохыг хичээх болно.

Гэвч өнөө үед сав л хийвэл бусдыг буруутгадаг, хүмүүсийг олоход их хялбар болжээ. Энэ зөвхөн хувь хүмүүсийн хооронд биш олон нийтийн танил хүмүүсийг хүртэл шүүж дүгнэн буруу зөрүү ярьдаг болсон байна. Яг юу болсоныг нь үнэн зөвөөр мэдэхийг оролдохын оронд шууд л өөрийнхөөрөө бусдыг буруутгаж, шүүж эхэлдэг байна.

Иаков 4:12 "Хууль Тогтоогч ба Шүүгч нь зөвхөн ганц байдаг бөгөөд Тэр нь аварч, устгаж ч чадна. Харин

хөршөө шүүгч та хэн юм бэ?" гэж бидэнд сануулсан байдаг. Хэн нэг хүн илт буруу зүйл хийлээ гэж бодъё. Яг энэ тохиолдолд сүнслэг хайртай хүмүүсийн хувьд түүний буруу, зөв нь огт хамаагүй харин явал түүнд хэрэгтэй байх вэ гэж бодон зөвхөн түүнийг л сүнсээр өсч Бурханы хайрыг илүү их аваасай гэж хүсч байдаг юм.

Сургаалт үгс 10:12т "Үзэн ядалт нь эвдрэлцлийг төрүүлдэг бол Хайр бүх нүгэл хилэнцийг далдалдаг." гэсэн байдаг бөгөөд бид бусдын бурууг уучилж, цаашлаад гэмшихэд нь туслах хэрэгтэй. Мөн жинхэнэ үнэнийг зааж, тэдний зүрх сэтгэлд нь хүрсэнээр үнэн зөв замаар явж, өөрсдийгөө өөрчилж чаддаг. Бидэнд бусдыг буруутгаж, шүүн дүгнэх бодол байхгүй бол хүн бүхнийг хайраар өвөрлөн, ямар ч хүнтэй уулзсан аз жаргалаар дүүрэн байх болно.

Бурханы хүслийн эсрэг, зөрчилдсөн бодол санаа танд байдаг уу?

03

Энэ дэлхийд хүмүүс ухамсар, хүний мөс чанар, ёс суртахууныхаа хирээр сайхан амьдардаг гэж ярьдаг. Гэвч ухамсар ч, ёс суртахуун ч сайхан сэтгэлийн төгс хэмжүүр болж чадахгүй. Энэ хоёр чанарт хоёуланд нь Бурханы Үгийн эсрэг зүйл байдаг. Зөвхөн Бурханы Үг л сайхан сэтгэлийг хэмжих төгс хэмжүүр болж чаддаг юм. Яагаад гэвэл Бурханы Үг нь ямар ч бодол санаатай таарч тохирдоггүй юм.

1 Иохан 3:4-г уншвал "Нүгэл үйлддэг хүн бүр бас ёс бус хэрэг үйлддэг. Нүгэл бол ёс бус хэрэг юм" гэснийг харвал нүгэл бол Бурханы хуулын эсрэг хийж байгаа ёс бус хэрэг юм. Тиймээс гэм нүгэл, ёс бус хэрэг хоёулаа үнэний эсрэг, Бурханы үгийн эсрэг зүйл юм. Үүнийг модтой харьцуулж үзвэл хорон муу, ёс бус зүйл нь нүдэнд харагдахгүй үндэс нь, гэм нүгэл нь мөчир, навч, үр жимснүүд нь юм. Үндэсгүйгээр мод салаалан мөчирлөж, навч, үр жимсийг ургуулж чадахгүй. Тиймээс гэм нүгэл нь хорон муугаас бий болдог байна.

Хорон муу бодол гэм нүглийг хийдэг. Жишээ нь: хэрэв та үзэн яддаг дургүй хүндээ муу муухай үг хэлвэл энэ нь хорон муугийн хандлага, таны дотор байгаа үзэн ядалт, дургүйцэл чинь гадагшаа хорон муу

үг болж гарч байна гэсэн үг. Эндээс бид зүрх сэтгэл дотор жаахан л хорон муугийн хэлбэр байвал илт, бүр улаан цайм биш ч гэм нүгэлийг үйлдэж байна гэдгийг ойлгох хэрэгтэй.

Бурханы үг сургаалыг сонсож, үг сургаалаар сайн зэвсэглэвэл өөрийгөө хянаж, зүрх сэтгэлд нь хорон муугийн хэлбэр байсан ч гэм нүгэл хийхээс зайлсхийж чаддаг байна. Гэсэн ч зүрх сэтгэлийнхээ гүнд хүртэл байгаа хорон муугийн хэлбэрийг хаяж байж л сая ариусаж, ариун сэтгэл зүрхтэй болж чадна. Хүн бүр эцэг эхээсээ хорон муугийн хэлбэрийг өвлөж төрдөг ч бүр илэрхий гадагшаа гарах нөхцөл шалтгаан байхгүй л бол тэр бүр илрээд мэдэгдээд байдаггүй байна. Тийм учраас 1 Тесалоник 5:22т "Бузар муугийн алив хэлбэрийг цээрлэгтүн." гэж бичсэн байдаг.

Хайр бол Хуулийн биелэлт юм. Тиймээс Хайргүй байх нь Хуулийн эсрэг зүйл бөгөөд хорон муу, гэм нүгэл юм (1 Иохан 3:23; Ром 13:10). Өөрөөр хэлбэл, бид муутай тооцоо хийж байна уу, үгүй юу гэдгээ шалгах нь бидний дотор хайр хэр зэрэг байгааг бодож, цэгнэж болно гэсэн үг. Бурхан Аавыг хэр их хайрлаж байгаа тэр хэрээрээ бусдыг хайрлаж, муутай тооцоо хийхгүй байж чадна.



## “Эзэн Балканы хойг болон Европд хамгийн сайн эмч болох Эзэнийг тунхаглах болно”



Dr. Любка Танчева (WCDN Захирал, Болгар)

Би Болгарын Зүүн Ортодокс Сүмийн итгэгчийн гэр бүлд төрсөн. Манай гэр бүл коммунист болон шашингүй үзэлтний засгийн газрийн дарамтан дор байлаа. Тэр үед би Бурханыг мэдэж байсан ч Түүнтэй хувьчлан уулзаагүй байсан. Коммунист дэглэм нурсаны дараа хүмүүс сүнсний хувьд өлсгөлөнд нэрвэгдэж энд тэндгүй хэрэн тэнүүчилж байв. Яг тэр үед би хамт ажилладаг нэг хүнээс сайн мэдээг сонсож, Есүсийг аврагч Эзэнээр хүлээн авсан юм.

Би Болгарын Шинжлэх Ухааны Академд Нейробиологийн Их Сургуулийн профессороор ажиллаж, Бурхан бол Бүтээгч Эзэн гэдгийг тарааж байгаа билээ.

### Бурхан надад WCDN-г мэдүүлж өгсөн

2011 оны нэгэн өдөр академийн зөвлөлийн гишүүн байхдаа танилаараа дамжуулан Израйлаас ирсэн пастор Даниел Розентэй танилцаж түүнийг мэддэг болсон.

Бид анх Австралийн Брисбанд зохион байгуулагдсан WCDN-ийн Олон Улсын Христчин Эмч нарын 8 дах удаагийн Их Хуралын үеэр танилцсан. WCDN (Дэлхийн Христчин Эмч нарын Холбоо, www.wcdn.org)-г Христчин Эмч нар эмнэлгийн нотлох баримтанд тулгуурлан Бурханы эрх мэдэлт хүчээр эдгэрсэнийг батлах зарилгоор 2004 онд байгуулсан. Олон Улсын Христчин Эмч нарын Их Хурал “Анагаах Ухаан ба Сүнслэг орчин” сэдвийн дор явагдаж Библи жинхэнэ үнэн болохыг баталж, Бурханы хүчээр эдгэрсэн олон тохиолдлуудыг харуулдаг билээ.

Яг үнэндээ бол би өөр нэгэн эмч нарын хуралд оролцож байгаад WCDN-д онцгой тохиолдлоор зочилсон юм. Тэнд би анх удаа Бурханы хүчээр эдгэрсэн олон тохиолдлуудыг харж, гэрчлэлүүдийг сонсож байхдаа Ариун Сүнсний оршихуйг мэдэрч билээ. WCDN-ийг үндэслэгч, захирал, И Жей руг Тэргүүн пасторын залбирлаар олон гайхамшигууд бий болсон гэрчлэлүүдийг өөрийн нүдээр харсан. Энэ бол жинхэнэ гайхамшиг байсан бөгөөд энд хүрэлцэн ирж оролцсондоо туйлын их баяртай байлаа.

Болгарт буцаж ирээд авсан ивээл, төрсөн сэтгэдлээ Христийн Софиа Төвийн Пастор Иван Хазарбассановтой хуваалцсан. Тэд чин сэтгэлээсээ хүлээн авч, Болгарт WCDN-ийн үйлчлэлийг эхлүүлсэн юм.

Би И Жей руг Тэргүүн пасторын үйлчлэлээр дамжуулан Ариун Сүнсээр дүүрсэн

WCDN-ий үйлчлэлийг хийснээс хойш миний итгэлийн амьдрал маш их эрч хүчтэй болсон. Тэргүүн Пасторын *Тэнгэрийн Орон I, II; Там*, гэсэн номуудыг уншиж эхэлсэн бөгөөд түүний намтар *Миний Амьдрал, Миний Итгэл* гэсэн номыг Австралийн Их Хуралд оролцож байхад өгсөн юм. Эдгээр номнуудын уншиж байхдаа би Ариун Сүнсээр дүүрч, агуу их мэргэн ухааныг олж авч, амьдрал маань ивээл ерөөлөөр дүүрэн болж байлаа. Үүнээс хойш би И Жей руг Тэргүүн пасторын номнуудыг дэмжигч нь болсон юм даа.

Одоо би Есүс Христийн жинхэнэ хайр ариун зар, сайн мэдээг тараасан *Загалмайн Утга Учир* номыг уншиж байна. Энэ ном маш сүнслэг, ойлгоход хялбар учраас загалмайн гал халуун хайрыг ойлгож, сүнслэг гүн гүнзгий утгатай маш олон зүйлийг ухаарч байгаа. Энэ номонд гарч байгаа мэдээлэл нь Христчин хүн бүрт зайлшгүй хэрэгтэй.

2013 оны 10-р сард догдолсон, хүсэн тэмүүлсэн сэтгэлээр Солонгосын Сөүл хотод байдаг Манмин Төв Сүмд очиж тэмдэгт гайхамшигуудыг харж Ариун Сүнсээр дүүрсэн юм. Сүмийн итгэгчидийн амьдрал үнэхээр гайхамшигтай. Урьд өмнө нь Европын Сүмүүдэд хэзээ ч мэдэрч байгаагүй тийм халуун дулаан, дотно, хайр дүүрэн орчинд орж, Ариун Сүнсээр дүүрч байгаагаа мэдэрч байлаа. Тэд нэгнээ маш их хүндэтгэн хайрлаж, хайрын хэлээр ярилцаж, Эзэний өмнө цэвэр зүрх сэтгэл, бодол санаагаар мөөргөл үйлдэж байсан.

Гадаадын олон оронд нэгдсэн их цуглаан зохион байгуулж, дэлхийн хэмжээний үйлчлэлийг хийдэг хамгийн дээд түвшинд хийсэн И Жей руг Тэргүүн пастортай уулзах завшаан олдсон билээ. Тэр маш даруухан, сайхан сэтгэлтэй, надад маш гүн сэтгэгдэл төрүүлсэн бөгөөд Болгарын Христэд итгэгчдийн талаар асуусан. Би түүний асуултанд Европын

Христэд итгэгчид дээр үеийнх шигээ тийм ариун нандин сургаал номлохоо больсон. Харин Болгарт зохион явуулах Их Хурлаас асар олон хүн ивээл авч, ухаарч ойлгоно гэдэгт итгэлтэй байна гэж хариулахад тэр чин сэтгэлээсээ туслах хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн юм.


Бурханы хүчээр Балканы Хойгын бүх орнууд, Европ тэр чигээрээ сэргэх болно гэдэгт би итгэлтэй байна

2013 оны 10 сарын сүүлчээр сайн мэдээ анх тунхаглагдсан газар болох Израйльд Ариун Сүнсний гайхамшигт ажлуудыг би гэрчилсэн билээ. Би И Сү жин пасторын Олон Улсын Конвенцийн Төвд зохион байгуулсан Израйлийн Нэгдсэн Их Цуглаанд WCDN-н гишүүний хувьд хүмүүсийн гэрчлэлүүдийг цуглуулахаар оролцсон билээ.

Израйлийн газар бүрээс, Палестин, Англи, Болгар, Энэтхэгээс олон эмч нар оролцохоор ирсэн. Урлагын тоглолт гайхамшигтай байсан бөгөөд И Сү жин пасторын номлол маш хүчтэй, сэтгэл хөдөлгөм сургаал байлаа. Асар олон хүн эдгэрсэнээ гэрчлэхээр урт дараалал үүсгэн хүлээн зогсож байсан. Хүмүүс шууд эдгэж байгааг хараад би үнэхээр гайхаж бас бахархаж байв.

И Сү жин пастор өвчтэй хүмүүсийн төлөө И Жей руг Тэргүүн пастор залбирч өгсөн эрх мэдэлт хүчтэй гар алчуур (Үйлс19:11-12)-ын залбирал хийсний дараа нурууны өвчин, өвдөгний өвчин, хөлний өвчин эдгэрсэн, хараа сайжирсан, дүлий хүн сонсголтой болсон, маш олон төрлийн хорт хавдарууд эдгэрсэн, бүр татаж унадаг өвчтэй хүн хүртэл эдгэрсэн гэж гэрчилж байлаа. Тэд бүгд Бурханыг алдаршуулсан. WCDN-ий байрлах газарт маш олон гэрчлэлүүд цугларч, Христчин хүний хувьд хүмүүс Бурханы хүч чадлыг мэдүүлэх хараа, зөн совин, хүсэл маань маш хүчтэй төрж байсан юм.

Одоо би WCDN-ийн Болгар дахь салбарын захирлаар ажиллаж байгаа бөгөөд 2014 оны 5 сард Софид болох 11 дэх Их Хуралд бэлтгэж байна. Есүс Хрис бол хүний бие махбод, сүнс сэтгэлийг анагаах хамгийн гайхамшигтай эмч гэдгийг батлах эмнэлгийн нотлох баримттай мэдээлэлийг цуглууж байгаа учраас зүрх сэтгэл минь маш их догдолж байна. Балканы Хойгын Орнууд болон Европд Ариун Сүнсний гал дүрэлзэн асахын төлөө залбирч байна.



### Мөргөлийн цагийн хуваарь

Мөргөл	Цаг
Хүндэтгэлийн их мөргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойшхи мөргөл	Ням гариг 11: 30
3 дахь өдрийн мөргөл	Лхагва гариг 18: 00
5 дахь өдрийн мөргөл	Баасан гариг 21: 30
Хүүхдийн цуглаан	Ням гариг 09: 00
Сурагчдын цуглаан	Бямба гариг 15: 00
Залуучуудын цуглаан	Мягмар гариг 17: 00

### залбирал цагийн хуваарь

Ангилал	Цаг	Удирдагч
Үүрийн залбирал	05:00-06:00	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Өглөөний залбирал	Даваа-Баасан 09:30-10:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Оройн Даниел залбирал	Өдөр бүр 18:00- 19:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч

### Манай хаяг:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 12-р хороо, Хангайн 3-57 тоот Улаанбаатар Ариун баярт мэдээ чуулган

Чуулганы утас: 976-11-351437

Чуулганы хариуцсан төлөөлөгч:  
Г. Анхбаяр СМТ 976-91173712  
976-91615337

Е- шуудан : power3712@gmail.com

Mongolian

### Манмин Мэдээ

Published by Манмин Төв Сүм

Сөүл хот, Гүрү дүүрэг, дижитал-26-29 тоот  
152-848 Солонгос Улс  
Утас: 82-2-818-7047 • Факс: 82-2-2818-7048  
http://www.manmin.org/english  
www.manminnews.com  
e-mail: manminministry@manmin.org  
Нийтлүүлэгч: Жаерок Лее  
Редактор: Геумсун Вин